

Амрагчдад үйлчлэх журам:

1. Амралтад ирсэн дариуд хүлээн авахад бүртгүүлж захиалсан өрөөний түлхүүр, өрөөгөө хүлээн авна.
2. Хүлээн авсан өрөөний тавилга, эд зүйлсийг Э-майлд ирүүлснээр байгаа эсэхийг шалгаж буцах үед тоо ёсоор хүлээлгэн өгнө.
3. Цагаан хэрэгслийг амрагч өөрөө авч ирэх үүрэгтэй ба нэмэлт цагаан хэрэгсэл авах бол 1 хэрэгслийг өдрийн 2000 төгрөгөөр тооцоо хийж авна.4
4. Нэгдсэн хоолоор үйлчлүүлэх бол хүний бүрийн тоогоор тооцон хоолны захиалганд бичүүлж цаашид хоолоор үйлчлүүлнэ.
5. Хоолны захиалгыг зөвхөн өрөөний захиалганд орсон, биеэр ирсэн үед авах ба урьдчилж авахгүй.
6. Хоолны тооцоог буцах үед өдрийн тарифын дагуу төлнө.
7. Өглөө,өдөр, оройн хоолны цагт хоцрохгүй орж байх. Өглөөний цай 08:00-09:00, өдрийн хоол 12:00-13:00, оройн хоол 18:00-19:00 цагт орно. Захиалгын хугацаанд тасралтгүй хоолонд орохыг анхаарна уу. (Жишээ нь зарим өдөр хоол идээгүй гэсэн асуудал гаргахгүй.)
8. Хэрэв өрөөний эд зүйл гэмтсэн дутсан, ашиглах боломжгүй болсон, хэт бохирдуулсан бол тарифын дагуу нөхөн төлбөрийг амралтад төлнө.
9. Орой цагаар (22:00 цагаас хойш) чанга дуу чимээ гаргахгүй байх, бусдын амгалан байдлыг алдагдуулахгүй байхад анхаарах.
10. Амралтын өрөөний эд зүйлс, тавилгыг өрөө хооронд зөөхгүй байх. Хүлээлгэж өгөхдөө анхны байдлаар нь хүлээлгэн өгөх
11. Өрөөний өдөр тутмын цэвэрлэгээгээ өөрсдөө хариуцах ба гарсан хог хаягдлыг анхнаас нь ялгаж зориулалтын цэгт цэгц байршуулах.
12. Ариун цэврийн өрөө, суултуурыг боловсон ёсонд нийцүүлэн хэрэглэх, суултуур, гар угаагуурт бөглөрөл үүсгэх зүйл хийхгүй байхад анхаарах.
13. Амрагч захиалсан хугацаанаа эрт буцах бол нэн дариу амралтад мэдэгдэх ба энэ тохиолдолд ямар нэг алданги, бусад төлбөр тооцохгүй тул төлбөр төлөх шаардлагагүй.
14. Хэрэв захиалсан өрөөнд сунгалт хийх бол аль болох эрт амралтад мэдэгдэх ба захиалгын **хугацаа дуусахад дараагийн зочинд хүндэтгэлтэй хандаж өрөөг суллах үүрэгтэй. Энэ тохиолдолд амралтаад өөр боломжтой өрөөнд шилжүүлэх** арга хэмжээг авна. Шилжсэн өрөө нь үнийн зөрүүтэй бол зөрүү төлбөрийг амрагч төлнө. Харин бага үнэтэй бол тухайн үнээр тооцож төлбөр төлнө.
15. Захиалгыг 10 хоногийн өмнө буцаасан бол 1000 төгрөг, 3 хоногийн өмнө буцаасан бол 5000 төгрөг, тухайн захиалгын хугацаанд бол 10000 төгрөгийн шимтгэл төлнө.
16. Захиалагч захиалсан хугацаандаа ирээгүй, ирэхгүй тухайгаа тодорхой мэдэгдээгүй бол (20:00 цаг хүртэл хүлээлгэнд байна) автоматаар цуцлагдана.
17. Захиалсан өрөөнд өөрөөний заагдсан хэмжээнээс илүү хүн байрлахгүй байх
18. Амралтын эзэмшлийн талбайд асар, майхан барихгүй байх.
19. Амрагчид амралтын нийтлэг үйл ажиллагааны талаарх санал хүсэлтээ хэлж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шийдвэрлүүлэх эрхтэй.
20. Амрагчийн илгээх хуудсыг тухайн төлсөн дүнд тохирсон байдлаар саадгүй бичилт хийжгэж, тамга даруулах эрхтэй.